



Аудитын код: САГ-2018/21/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

Аудитор Б.Сэржмядаг

Аудитор Б.Уянга

Аудитор П.Амарсанаа

Улаанбаатар хот



Агуулга

1.	Аудитын хураангуй тайлан	2
2.	Аудитын гэрчилгээ	8
3.	Аудитын тайлан.....	10
3.1	Оршил.....	10
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	10
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	11
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	13
3.5	Дотоод аудит	14
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	15
3.7	Шилэн дансны мэдээлэл	16
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	17
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	17
3.9.1	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар	17
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар ...	19
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	20
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд	20
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	20
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	21
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	21
3.16	Үр өгөөжийн тооцоолол	21
4.	Менежментийн захидал	22
4.1	Төсөл, хөтөлбөрийн нэгжийн талаар	23
4.2	Дотоод аудитын талаар	24
5.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	25
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	25
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	26
5.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	27
5.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	28
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	29
5.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	31





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

2018.05.04 № 1108

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



070522

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

3. Аудитын тайлан

3.1 Оршил

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.


3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.7-д заасны дагуу Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (цаашид УСНББОУС гэх), түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.



Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 26-наас 2018 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 5 дугаар сарын 04-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Сэржмядаг, Б.Уянга, П.Амарсанаа нар хариуцаж хэрэгжүүлэв.


Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт Сангийн яамны 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 12-1/1989 дүгээр албан бичгээр Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сангийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засаг, санхүү, төсвийн таатай орчин бүрдүүлэх, санхүү, эдийн засгийн оновчтой удирдлагаар хангахад оршино.

Сангийн яам нь дор дурдсан үйл ажиллагаа, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Санхүү, төсвийн удирдлагын чадавхийг бэхжүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах;
- Санхүүгийн салбарын зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн бодлого явуулах;
- Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах;
- Гадаадын санхүүжилттэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулалтаар хангах, боловсронгуй болгох, хэрэгжилтэд нэгдсэн хяналт тавих, гадаад, дотоод өрийн удирдлагыг бэхжүүлэх, хяналтыг чангатгаж үр нөлөөг дээшлүүлэх;
- Нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого, удирдлагаар хангах;
- Төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- Санхүүгийн дотоод хяналтын бодлого, удирдлагаар хангах;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, хяналт зохицуулалтыг сайжруулах;
- Яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх;
- Улс орны санхүү, төсвийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээгээр хангах, сайд, Засгийн газрын Танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангах, санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөгөө, үйлчилгээг мэргэшлийн өндөр түвшинд үзүүлэх явдал байна.




Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын зарим үйл ажиллагааг төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан болно.

Сангийн сайд тайлант хугацаанд Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 191 арга хэмжээ төлөвлөснөөс 92.3 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын 2017 төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан Сангийн сайдын 2017 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнг чанарын болон тоон үзүүлэлтээр дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт №1. Сангийн сайдын 2017 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2017 оны зорилтот түвшин	Биелэлт
Санхүү, төсөв, эдийн засгийн нэгдсэн удирдлага			
20.1	20.1.1 Монгол Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв болон Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх	хуульд заасан шаардлагад нийцсэн байх	Монгол Улсын Засгийн газрын зүгээс ОУВС-тай хамтран 3 жилийн хугацаатай “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот түвшнийг 2017-2023 он хүртэл дахин тодорхойлох зайлшгүй шаардлага үүссэний дагуу 2017 онд 10.6 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, 2022 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар, 2023 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байхаар өөрчилсөн. Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг 2016 онд 88 хувь, 2017 онд 85 хувь, 2018 онд 80 хувь, 2019 онд 75 хувь, 2020 онд 70 хувь, 2021 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар Монгол Улсын 2017 оны төсөвт тусгасан байна.
Татвар хураалт, орлого бүрдүүлэлт			
20.2	20.2.1 Улс, орон нутгийн төсөвт орох татварын орлогын төлөвлөгөөний биелэлт /хувиар/	100	116.8
	20.2.2 Урьд оны тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалт /хувиар/	75	



**Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

20.2.3	Урьд оны хяналт шалгалтаар ногдуулсан өр барагдуулалт /хувиар/	75	32.9
20.2.4	Тайлант хугацааны татварын тайлангийн ногдол өр барагдуулалт /хувиар/	90	85.9
20.2.5	Тайлант хугацааны хяналт шалгалтын ногдол өр барагдуулалт /хувиар/	80	62.2
20.2.6	Татварын цахим тайлан авалт /хувиар/	93	81.1
20.2.7	Татварын зөрчлийн бууралт /хувиар/	6	2.9
20.2.8	Алдагдалтай буюу "Х" тайлан тушаалтын бууралт /хувиар/	1.0-2.0	2.0
20.2.9	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх /хувиар/	2	1.8
20.2.10	Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх /хувиар/	0.1-0.5	3.5
20.2.11	Бусад төрлийн татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх /хувиар/	0.5-2.6	2.8
20.2.12	Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хэрэгжилт /хувиар/	50	59.8
20.2.13	Худалдааг хөнгөвчилж гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулах /хувиар/	70	70

Эх сурвалж: "shilendans.gov.mn" сайт.


3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 - 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Засгийн газрын Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас тавьж буй дотоод аудитыг үнэлж баримтжуулав.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 13 чиглэлээр түүвэрчилсэн төрийн аудитын байгууллага горимыг гүйцэтгэж баримтжууллаа.



Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой танилцахад 2017 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дараах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэж үзлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод аудит


Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод аудитыг “хангалтгүй” гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим, сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд зээл, тусламжаар хэрэгжиж буй 10 зээлийн төсөл, 1 буцалтгүй тусламжийн төслүүдийн 2017 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 3 төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын 2016 он, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийжээ.



Хүснэгт №2. Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	3	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	3	
3	Шалгалтанд хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	13	
4	Илрүүлсэн зөрчлийн	Тоо	13
		Дүн /сая.төг/	8,521.4
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	18
		Дүн /сая.төг/	8,521.4
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын дүн	Тоо	2
		Дүн /сая.төг/	7,124.5

Эх сурвалж: Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын 2017 оны тайлан.

Дотоод аудитаар нийт 8,521.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, тооцоо, судалгаанд үндэслэн зээлийн хэлэлцээрийг байгуулдаг байх, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төслийн зорилтод тодорхойлогдсон бодлогын эрх зүйн баримт бичиг, шийдвэрт орох өөрчлөлтүүдийг боловсруулах, батлуулах, ажлуудыг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэхэд ажлыг эрчимжүүлэх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, авлага барагдуулах, банкуудын харилцах, хадгаламжийн үлдэгдэлд шууд хяналт тавих хууль, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зэрэг 18 зөвлөмж өгч ажиллажээ.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга


Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Сангийн сайдын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнг 15 үзүүлэлтээр зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Сангийн сайдын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 4,366,835.2 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №3. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татварын ерөнхий газар	2,318,513.7	2,812,683.5	494,169.8
Үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд	242,417.9	325,680.2	83,262.3
Ирээдүйн өв санд	333,345.1	357,722.8	24,377.7
Гаалийн ерөнхий газар	1,897,248.8	1,950,656.1	53,407.3
Сангийн яам	16,529.3	25,108.3	8,579.0
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	121,427.0	117,493.2	(3,933.8)
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	9,796.9	6,398.5	(3,398.4)
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,319.5	11,609.3	8,289.8
Нийт дүн	4,366,835.2	4,923,948.9	557,113.7

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж улсын төсвөөс 1,621,466.2 сая төгрөг, гадаадын зээлийн эх үүсвэрээс 86,554.4 сая төгрөг, гадаад тусламжийн орлогоос 9,796.9 сая төгрөг, өөрийн орлого 3,319.5 сая төгрөг нийт 1,721,137.0 сая төгрөгийн эх үүсвэр, үүнээс төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх орлого 110,927.0 сая төгрөг батлагдсан байна.



Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,616,686.1 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, гадаадын зээлийн эх үүсвэрээс 88,179.8 сая төгрөг, гадаад тусламжийн орлогоос 6,398.5 сая төгрөг, өөрийн орлого 11,609.3 сая төгрөг, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс 117,493.2 сая төгрөгийн орлого бүрдсэн байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Сангийн сайдын төсвийн багцад 9,489,767.6 сая төгрөг, үүнээс Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт 7,590,430.2 сая төгрөг, Засгийн газрын гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 167,700.3 сая төгрөг зарцуулагдахаар батлагдсан байна.

Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт 7,590,430.2 сая төгрөг, Засгийн газрын гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 167,700.3 сая төгрөгийн зарцуулалтыг улсын төсвийн данснаас шилжүүлэгдэж Төв төрийн сангийн санхүүгийн тайланд тусгагдаж, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд тусгагдах тул дараагийн аудитаар хамруулна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын урсгал зардалд 1,514,358.4 сая төгрөг /улсын төсвөөс 1,483,116.7 сая, гадаад зээл, тусламжийн орлогоос 31,241.7 сая/, хөрөнгө оруулалтын зардалд 18,098.7 сая төгрөг /улсын төсвөөс 8,639.7 сая, гадаад зээл, тусламжийн орлогоос 9,459.0 сая/, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд 77,753.0 сая төгрөг нийт 1,610,210.1 сая төгрөг зарцуулахаар батлагджээ.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нийт зарлага, цэвэр зээлийн дүн 1,577,862.5 сая төгрөгт хүрч 98.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 6,729.7 сая төгрөгийг Төв төрийн санд төвлөрүүлсэн байна.


Сангийн сайдын төсвийн багцад улсын төсвөөс 8,639.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт батлагдаж /Гаалийн ерөнхий газар 1,400.0 сая, Татварын ерөнхий газар 1,500.0 сая, Сангийн яам 429.7 сая, Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз 5,310.0 сая/, гүйцэтгэлээр 8,222.6 сая төгрөг зарцуулсан байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар зардал хэтрээгүй байна.

Нэмэлт санхүүжилтээр Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 5,619.2 сая төгрөгийн орлого бүрдэж, 5,608.5 сая төгрөг зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Сангийн сайд, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлсэн байна. Үүнд:



- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт (бүтэн жилээр);
- Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр);
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр);
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр);
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр) зэрэг болно.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 45 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл


3.9.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар

а. Төсөвт байгууллагууд

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа 57 төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангаас 5 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 7 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 45 санхүүгийн тайлан /4 санхүүгийн тайланд хараат бус аудитын компаниуд, 41 санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллага/, 2 санхүүгийн нэгтгэсэн тайланд /Үндэсний аудитын газар/ аудит хийж дүгнэлт хүргүүлээ. Аудитад хамрагдсан байгууллагуудаас 45 байгууллагад “Зөрчилгүй”, 2 байгууллагад /БЗД-ийн татварын хэлтэс, СХД-ийн татварын хэлтэс/ “Хязгаарлалттай”, санал дүгнэлт өгсөн. Үүнд:

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл:

1. Баянзүрх дүүргийн татварын хэлтэс - “Ерөнхий журналын НББ-ыг зохих аргачлалын дагуу бэлтгээгүй, үндсэн хөрөнгөнд тооллого хийж тооллогын комисс илтгэх хуудас бичсэн боловч нягтлан бодогч хөрөнгийн үлдэгдлийг мутулган баталгаажуулж, тооцоог бодож акт үйлдээгүй, шатахууны зарцуулалтын тооцоог бодож, үр дүнг тайланд тусгаагүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.”



2. Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс - “Бусад үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн 4.5 сая төгрөгийн үлдэгдлийг тоолоогүй, тооллогын бүртгэлээс тоног төхөөрөмжийн үлдэгдлийг 0.2 сая, бараа материалын үлдэгдлийг 11.1 сая, үнэт цаасны орлогыг нярвын тайлангийн орлого 2.5 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан, байгууллагын ой тэмдэглэх, шинэ жилийн арга хэмжээнд 12.1 сая төгрөгийг зарцуулсан, цалин хөлсийг 0.1 сая төгрөгөөр илүү олгосон, 35.5 сая төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, үр дүнгийн урамшууллаас 1.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй зэрэг зөрчлүүд нь тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.”

Аудитаар нийт 5,885.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 5,176.0 сая төгрөгийн алдааг залруулж, хууль, эрх зүйн актуудыг зөрчсөн 22.4 сая төгрөгийн зөрчилд 10 акт, 247.4 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, 440.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 87 зөвлөмж өглөө.

б. Төсөл, хөтөлбөрийн нэгжүүд

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 15 төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлангаас хараат бус аудитын компани 5 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт хүргүүлсэн, Үндэсний аудитын газар 9 төслийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 1 төслийн нэгж нь байгуулагдаагүй шалтгаанаас санхүүгийн тайлан гараагүй байна.

Аудитаар нийт 8,765.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 8,122.7 сая төгрөгийн алдааг залруулж, хууль, эрх зүйн актуудыг зөрчсөн 643.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 18 зөвлөмж өглөө.


в. Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 10 төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангаас Үндэсний аудитын газартай хийсэн гурвалсан гэрээгээр 5 байгууллагын санхүүгийн тайланд, Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалтаар 5 байгууллагын санхүүгийн тайланд хараат бус аудитын компаниуд аудит хийж, аудитад хамрагдсан 10 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 422.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 212.2 сая төгрөгийн алдааг залруулж, хууль, эрх зүйн актуудыг зөрчсөн 210.7 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өглөө.

г. Засгийн газрын тусгай сан

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын тусгай сангийн 4 санхүүгийн тайлангаас Засгийн газрын нөөц сангийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, тусгай сангийн 3 санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.



Аудитаар нийт 397.7 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлээ.

3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын талаар

- Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагч болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 4.7-д “Төсөвт байгууллага, төсөл сан, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, холбогдох заавар, журамд нийцүүлэн гаргасан тайлан, тодруулгыг хуулийн хугацаанд нь харьяалах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж харьяа байгууллагууд санхүүгийн тайлангаа “Э-тайлан” програмд шивэхдээ аудит хийгдсэн үр дүнгийн тайлангийн орлого, зардлаас 1,043.5 сая төгрөгөөр зөрүүтэй шивж /Зээлийн батлан даалтын сан 79.5 сая, Хөгжлийн банк 880.5 сая, Хөдөө аж ахуйн давхар даатгал 83.5 сая төгрөг/, санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн орлого, зардлыг дутуу илэрхийлсэн нь тайлант үед хамаарах ажил гүйлгээний талаарх иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.


Шийдвэрлэсэн нь: Дээрх алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулав.

- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүгийн хяналт тавьж үнэлэх журам”-д заасан жишиг цалин, ажлын хөлсийг тогтоох үнэлгээний шалгуур, хөлсөөр ажиллах гэрээ, хүүгийн орлогын зарцуулалтын талаарх заалтууд нь Төсвийн тухай хуулийн 17.1-т “Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна” гэсэн заалт, Өрийн удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах;” гэсэн зарчимтай зөрчилдсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх журмыг холбогдох хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

- Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөл, хөтөлбөрийн нэгжүүд 2017 оны санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэсэн заалтын дагуу Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар “Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам”-д батлагдсан тайлан, тодруулгын маягтаар бэлтгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх хууль, журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.



• Харьяа байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 15,472.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 13,510.9 сая төгрөгийн алдааг залруулж, 22.4 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 10 төлбөрийн акт тогтоож, 247.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 12 албан шаардлага, 1,691.6 төгрөгийн алдаа, зөрчилд 120 зөвлөмж хүргүүлсэн байгаа нь Сангийн яамны Санхүүгийн эрсдэлийн удирдлагын газар Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д "... төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт өгөх, үнэлэлт зөвлөмж гаргах...", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ: 5.1.3. төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал;" гэж заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: Тус газар нь харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулж, түүнд тавих хяналтыг дээшлүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 2013-2016 онд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос Төв төрийн санд төвлөрүүлсэн 1,747.9 сая төгрөгийн авлага байна.


Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 196 дугаар тогтоолоор Гудамж төслийг татан буулгаж, Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийг баталж, төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулах уг тогтоолын 3 дугаарт "Гудамж төслийг татан буулгаж байгаатай холбогдуулан тус төслийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өр авлагыг тооцоо нийлж Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөлд балансаас балансад шилжүүлэх арга хэмжээ авах..." гэж заасны дагуу тухайн төсөлд бүртгэлтэй 56,207.3 сая төгрөгийн замыг ашиглагч орон нутгийн байгууллагуудад шилжүүлээгүй байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд 2018 оны завсрын аудитаар харьяа байгууллагуудын өөрийн орлогын бүрдүүлэлтэд нарийвчилсан горим, сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 16,515.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 14,554.4 сая төгрөгийн алдааг залруулж, 22.4 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 10 төлбөрийн акт тогтоож, 247.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 12 албан шаардлага, 1,691.6 төгрөгийн алдаа, зөрчилд 120 зөвлөмж хүргүүлсэн байна.



3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний аудитын газраас Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 80.2 хувьтай байна.

Зөвлөмжийн биелэлтийг Сангийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 13-2/1652 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг тооцохдоо 2016 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан дахь нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгов.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 2,768,883.9 сая төгрөг байгаа нь өмнөх оны нийт зардлаас 462,445.7 сая төгрөгөөр их байгаа тул төлөвлөлтийн үе шатанд тооцсон 46,129.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.


Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.14-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дугаар хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 964.0 сая төгрөгийн үр өгөөж тооцлоо.



4. Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Сангийн яамны холбогдох газрын санхүүгийн ажилтнууд болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 Төсөл, хөтөлбөрийн нэгжийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүгийн хяналт тавьж үнэлэх журам"-д заасан жишиг цалин, ажлын хөлсийг тогтоох үнэлгээний шалгуур, хөлсөөр ажиллах гэрээ, хүүгийн орлогын зарцуулалтын талаарх заалтууд нь Төсвийн тухай хуулийн 17.1-т "Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна" гэсэн заалт, Өрийн удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах;" гэсэн зарчимтай зөрчилдсөн байна.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөл, хөтөлбөрийн нэгжүүд 2017 оны санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар баталсан "Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" гэсэн заалтын дагуу Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар "Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам"-д батлагдсан тайлан, тодруулгын маягтаар бэлтгээгүй байна.

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх
Төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах

ҮАГ-ын зөвлөмж:


Журмыг холбогдох хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, төсөл хөтөлбөрийн нэгжүүд үйл ажиллагаандаа мөрдөх

Батлагдсан маягтын дагуу санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэж байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын танилцуулж



4.2 Дотоод аудитын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Харьяа байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 15,472.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 13,510.9 сая төгрөгийн алдааг залруулж, 22.4 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 10 төлбөрийн акт тогтоож, 247.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 12 албан шаардлага, 1,691.6 төгрөгийн алдаа, зөрчилд 120 зөвлөмж хүргүүлсэн байгаа нь Сангийн яамны Санхүүгийн эрсдэлийн удирдлагын газар Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д "... төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт өгөх, үнэлэлт зөвлөмж гаргах...", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д " Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах хүрээнд хийнэ: 5.1.3. төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал;" гэж заасан чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх
Төсвийн сахилга бат алдагдах

ҮАГ-ын зөвлөмж:

Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулж, түүнд тавих хяналтыг дээшлүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.

5. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,776,135,187.0	3,569,870,361.8
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,767,641,506.5	1,307,540,555.8
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	116,717,117.2	382,238,175.6
АВЛАГА	1,416,036,236.9	1,438,948,294.3
УРЬДЧИЛГАА	3,170,872.2	4,226,220.9
БАРАА МАТЕРИАЛ	4,132,241.9	69,910,378.6
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	468,437,212.2	367,006,736.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,373,600,573.3	3,763,389,288.1
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4,012,435,461.6	3,430,242,684.7
Урт хугацаат хадгаламж	107,681,806.5	39,473,008.5
Үнэт цаас	483,870,938.9	180,719,553.2
Урт хугацаат зээл	3,420,882,716.2	3,210,050,123.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	361,165,111.7	333,146,603.4
Биет хөрөнгө	231,806,158.9	264,457,321.1
Биет бус хөрөнгө	14,242,679.2	10,233,023.5
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	115,116,273.6	58,456,258.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,149,735,760.3	7,333,259,649.9
НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,046,818,517.0	6,150,127,283.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	605,661,020.6	1,403,238,281.8
Богино хугацаат үнэт цаас	14,993,838.2	-
Богино хугацаат зээлийн өглөг	469,126,322.7	1,290,967,945.4
Өглөг	120,520,481.0	76,360,683.7
Урьдчилж орсон орлого	1,020,378.6	35,909,652.6
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,441,157,496.4	4,746,889,002.1
Урт хугацаат үнэт цаас	7,716,000.0	814,291,730.0
Урт хугацаат зээл	5,433,441,496.4	3,932,597,272.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,102,917,243.2	1,183,132,366.1
Засгийн газрын хувь оролцоо	2,102,917,243.2	1,183,132,366.1
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	95,660,657.7	96,660,657.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,211,744,076.1	1,332,251,234.1
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	36,884,000.0	36,884,000.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	108,055,248.5	111,541,072.5
Хуримтлагдсан үр дүн	617,008,085.3	(422,240,915.8)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,565,175.7	28,778,292.5
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	(741,974.9)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,149,735,760.3	7,333,259,649.9

ТӨРИЙН АУДИТЧ БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,845,097,644.4	2,979,034,914.7
ТАТВАРЫН ОРЛОГО	1,000.8	683,403,003.6
Орлогын албан татвар	1,000.8	322,504,368.2
Хувь хүний орлогын албан татвар	1,000.8	-
ААН-ын орлогын албан татвар	-	28,251,636.8
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	294,252,731.4
Бусад татвар, төлбөр, хураамж	-	360,898,635.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	874,872,093.6	884,152,128.1
Нийтлэг татварын бус орлого	841,741,693.9	854,294,022.9
Хөрөнгийн орлого	-	-
Тусламжийн орлого	33,130,399.7	26,570,114.9
Зээлийн орлого	-	3,287,990.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,970,224,550.0	1,411,479,782.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,305,839,187.4	2,822,443,391.3
УРСГАЛ ЗАРДАЛ	2,280,819,224.4	2,819,005,762.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,947,216.5	330,830,549.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,089,164.7	91,549,505.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,010,835.8	10,086,521.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,691,788.6	10,052,580.5
Хангамж, бараа материалын зардал	6,869,332.2	8,599,152.6
Нормативт зардал	49,280.7	311,773.4
Эд хогшил, урсгал засварын зардал	1,022,527.1	1,811,243.7
Томилолт, зочны зардал	2,365,377.9	3,008,772.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,430,927.7	108,484,658.6
Бараа үйлчилгээний бусад зардал	203,417,981.8	96,926,340.9
ХҮҮ	1,531,273,040.6	1,524,129,982.7
ТАТААС	5,521,327.6	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	358,077,639.6	964,045,230.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,019,963.0	3,437,628.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	539,258,457.0	156,591,523.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	13,368,262.7	2,122,487.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	629,008,962.8	(15,628,706.6)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(76,382,243.0)	174,342,717.9



5.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	616,792,469.2	0.0	616,792,469.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	704,915,655.0	0.0	704,915,655.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,321,708,124.2	0.0	1,321,708,124.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	6,934,451.5	0.0	6,934,451.5
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	850,656,910.6	0.0	850,656,910.6
Тайлант үеийн үр дүн	(76,382,243.0)	0.0	(76,382,243.0)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,102,917,243.2	0.0	2,102,917,243.2
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,102,917,243.2	0.0	2,102,917,243.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,214,333,693.8)	0.0	(1,214,333,693.8)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	888,583,549.4	0.0	888,583,549.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(4,786,883.2)	0.0	(4,786,883.2)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	124,992,982.0	0.0	124,992,982.0
Тайлант үеийн үр дүн	174,342,717.9	0.0	174,342,717.9
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,183,132,366.1	0.0	1,183,132,366.1



5.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мян.төг/


Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,493,750,650.1	9,506,946,690.2
ТАТВАРЫН ОРЛОГО	627,180,647.8	683,403,003.6
Орлогын албан татвар	627,180,647.8	322,504,368.2
Хувь хүний орлогын албан татвар	627,180,647.8	0.0
ААН-ын орлогын албан татвар	0.0	28,251,636.8
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	294,252,731.4
Бусад татвар, төлбөр, хураамж	0.0	360,898,635.4
Бусад нийтлэг төлбөр, хураамж	0.0	360,898,635.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,190,735,038.8	6,527,957,611.0
Нийтлэг татварын бус орлого	1,157,485,487.1	6,521,559,118.4
Тусламжийн орлого	33,249,551.6	6,398,492.6
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,675,834,963.5	2,295,586,075.5
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,578,605,350.0	8,579,462,131.8
УРСГАЛ ЗАРДАЛ	3,578,605,350.0	8,579,462,131.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,286,079,022.1	6,045,844,917.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	92,517,380.4	88,646,629.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	10,549,567.4	10,141,892.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,202,756.7	9,954,476.2
Хангамж, бараа материалын зардал	17,110,195.2	8,248,437.6
Нормативт зардал	210,963.1	531,771.4
Эд хогшил, урсгал засварын зардал	1,336,517.0	2,706,530.9
Томилолт, зочны зардал	2,174,344.2	2,478,258.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	1,978,673,137.4	5,883,081,918.9
Бараа үйлчилгээний бусад зардал	172,304,160.8	40,055,002.4
ХҮҮ	926,331,693.4	1,498,885,325.1
ТАТААС	5,520,000.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	360,674,634.5	1,034,731,889.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	915,145,300.1	927,484,558.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	54,835,929.1	95,304,658.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	110,460,739.6	40,671,125.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	110,460,739.6	40,671,125.6
Дотоод эх үүсвэрээр	110,460,739.6	40,671,125.6
Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(55,624,810.5)	54,633,532.8
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	559,072,558.2	(1,442,219,041.9)
Бусад эх үүсвэр	1,212,972,622.6	123,125,120.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН	474,822,256.1	113,667,840.0
ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	179,077,808.2	1,451,676,322.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,418,593,047.8	(460,100,950.7)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	349,048,458.7	1,767,641,506.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,767,641,506.5	1,807,540,555.8

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНГАЛДҮНЭЛТ

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,610,210,093.1	1,577,862,547.1	32,347,546.0	97.99
УРСГАЛ ЗАРДАЛ	1,514,358,404.9	1,483,975,318.2	30,383,086.7	97.99
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	146,256,129.5	117,663,620.7	28,592,508.8	80.45
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,353,868.0	43,771,021.9	2,582,846.1	94.43
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,850,941.7	4,785,035.1	65,906.6	98.64
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,885,244.0	3,692,512.8	192,731.2	95.04
Хангамж, бараа материалын зардал	1,885,498.3	1,793,326.0	92,172.3	95.11
Нормативт зардал	524,396.2	522,907.2	1,489.0	99.72
Эд хогшил, урсгал засварын зардал	1,210,219.2	1,202,284.3	7,934.9	99.34
Томилот, зочны зардал	675,679.9	586,140.3	89,539.6	86.75
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,856,071.6	27,784,320.0	17,071,751.6	61.94
Бараа үйлчилгээний бусад зардал	42,014,210.6	33,526,073.1	8,488,137.5	79.80
ХҮҮ	1,156,688,128.5	1,156,465,120.8	223,007.7	99.98
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	548,100,000.0	547,963,877.1	136,122.9	99.98
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	608,588,128.5	608,501,243.7	86,884.8	99.99
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	211,414,146.9	209,846,576.7	1,567,570.2	99.26
Засгийн газрын урсгал шилжүүлэг	208,145,944.6	207,192,296.0	953,648.6	99.54
Бусад урсгал шилжүүлэг	3,268,202.3	2,654,280.7	613,921.6	81.22
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,098,737.3	8,900,905.2	9,197,832.1	49.18
Барилга байгууламж	429,700.0	81,500.0	348,200.0	18.97
Их засвар	336,000.0	298,038.2	37,961.8	88.70
Тоног төхөөрөмж	17,333,037.3	8,521,367.0	8,811,670.3	49.16
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	77,752,950.9	84,986,323.7	(7,233,372.8)	109.30
Эргэж төлөгдөх зээл	22,102,367.3	17,541,335.8	4,561,031.5	79.36
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	55,650,583.6	67,444,987.9	(11,794,404.3)	121.19
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,610,210,093.1	1,595,150,786.8	15,059,306.3	99.06
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,621,466,187.7	1,606,456,334.2	15,009,853.5	99.07
Улсын төсвөөс санхүүжих	1,621,466,187.7	1,606,456,334.2	15,009,853.5	99.07



**Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	89,873,951.7	99,789,167.9	(9,915,216.2)	111.03
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,766,302.9	9,414,443.3	(7,648,140.4)	533.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,553,237.2	2,194,939.9	(641,702.7)	141.31
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	86,554,411.6	88,179,784.7	(1,625,373.1)	101.88
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	9,796,938.5	6,398,492.6	3,398,445.9	65.31
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	9,796,938.5	6,398,492.6	3,398,445.9	65.31
БУСАД ЭХ ҮҮСВЭР	(110,926,984.8)	(117,493,207.9)	6,566,223.1	105.92
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(110,926,984.8)	(117,493,207.9)	6,566,223.1	105.92
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	43,132,154.2	(43,132,154.2)	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	50,653,794.0	(50,653,794.0)	0



5.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мян.төг/

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,608,463.8
УРСГАЛ ЗАРДАЛ	5,458,199.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,256,956.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,276,562.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,898.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,780.0
Хангамж, бараа материалын зардал	149,595.8
Нормативт зардал	640.0
Эд хогшил, урсгал засварын зардал	565,099.2
Томилолт, зочны зардал	13,837.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,842,619.5
Бараа үйлчилгээний бусад зардал	303,924.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,201,243.7
Бусад урсгал шилжүүлэг	1,178,451.6
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,792.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	150,264.0
Дотоод эх үүсвэрээр	150,264.0
Тоног төхөөрөмж	49,470.0
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	100,794.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,619,218.5
Нэмэлт санхүүжилтийн орлого	5,619,218.5
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	174,631.7
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,917,086.4
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,053,259.8
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,405,079.3
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих-Нэмэлт	69,161.3
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	10,754.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,484.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,238.9